

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/156/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99862066      Цахим хаяг: <a href="mailto:peakomaudit@gmail.com">peakomaudit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18_Тос95917377
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/156-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ  
СУМЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ДОЛГОРМАА  
ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>25,504,045.79</b>	<b>45,028,671.63</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,581,222.64</b>	<b>1,816,916.60</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,266,702.64	1,266,702.64
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>314,520.00</b>	<b>550,213.96</b>
33510	Байгууллагаас авах авлага	0.00	550,213.96
33520	Хувь хүмүүсээс авах авлага	314,520.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>23,922,823.15</b>	<b>43,211,755.03</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>23,922,823.15</b>	<b>43,211,755.03</b>
35410	Бичиг хэргийн материал	2,979,700.00	2,979,700.00
35420	Аж ахуйн материал	20,613,123.15	38,282,055.03
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	1,620,000.00
35470	Бусад хангамжийн материал	330,000.00	330,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,133,718,414.11</b>	<b>1,090,833,143.17</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,133,718,414.11</b>	<b>1,090,833,143.17</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,093,064,414.07</b>	<b>1,050,491,643.17</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,063,554,400.00	1,063,554,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-97,293,621.82	-145,847,162.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,912,500.00	14,912,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,135,416.40	-14,562,499.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	124,275,700.46	131,570,700.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,879,140.62	-93,356,027.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,370,750.50	116,784,123.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,499,259.48	-53,020,170.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,396,632.00	28,306,632.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,660,766.22	-6,034,099.60
39217	Ном	7,022,635.65	8,183,247.75
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>40,654,000.04</b>	<b>40,341,500.00</b>
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-199,999.96	-512,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	39,354,000.00	39,354,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,159,222,459.90</b>	<b>1,135,861,814.80</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,672,640.00</b>	<b>75,561.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,672,640.00</b>	<b>75,561.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>10,672,640.00</b>	<b>75,561.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>10,672,640.00</b>	<b>75,561.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	10,672,640.00	75,561.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,148,549,819.90</b>	<b>1,135,786,253.80</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,148,549,819.90</b>	<b>1,135,786,253.80</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	596,019,208.20	596,019,208.20
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-652,556,794.77</b>	<b>-665,320,360.87</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-592,934,649.55	-652,556,794.77
51220	Тайлант үеийн үр дүн	-59,622,145.22	-12,763,566.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,205,087,406.47	1,205,087,406.47
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,159,222,459.90</b>	<b>1,135,861,814.80</b>

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>705,794,310.66</b>	<b>739,793,972.67</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,124,972.06</b>	<b>39,178,507.68</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,124,972.06</b>	<b>39,178,507.68</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,545,193.25	23,198,984.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,579,778.81	15,979,522.88
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>693,669,338.60</b>	<b>700,615,464.99</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>571,353,800.00</b>	<b>559,465,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	571,353,800.00	559,465,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,699,600.00</b>	<b>7,520,100.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,698,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,699,600.00	2,822,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>111,615,938.60</b>	<b>133,630,064.99</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	111,615,938.60	133,630,064.99
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>765,416,455.88</b>	<b>752,557,538.77</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>765,416,455.88</b>	<b>752,557,538.77</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>730,041,893.57</b>	<b>710,389,958.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>443,479,457.69</b>	<b>433,534,180.00</b>
210101	Үндсэн цалин	289,083,480.00	291,432,961.00
210102	Нэмэгдэл	117,010,177.69	116,945,267.00
210104	Урамшуулал	37,385,800.00	25,155,952.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,152,300.00</b>	<b>55,745,507.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,329,400.00	38,891,505.45
210202	Тэтгэмжийн даатгал	4,455,700.00	4,367,631.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,564,600.00	3,470,585.47
210204	Ажилгүйдлийн даатгал	891,100.00	818,589.05
210205	Эрүүл мэндийн даатгал	8,911,500.00	8,197,195.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>122,288,578.60</b>	<b>122,511,824.99</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,851,728.60	8,073,043.23
210302	Түлш, халаалт	112,501,640.00	113,157,061.76
210303	Цэвэр, бохир ус	1,935,210.00	1,281,720.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,057,000.00</b>	<b>6,617,191.00</b>
210401	Бичиг хэрэг	200,900.00	352,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,980,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	178,200.00	1,551,200.00
210404	Ном, хэвлэл	771,100.00	1,815,400.00

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,984,800.00	513,091.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	942,000.00	885,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,140,120.00</b>	<b>14,935,400.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	142,500.00
210502	Хоол, хүнс	9,325,120.00	13,821,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	665,000.00	971,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,230,000.00</b>	<b>1,136,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,580,000.00	0.00
210604	Урсгал засвар	650,000.00	1,136,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,000.00</b>	<b>126,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	84,000.00	126,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,933,840.00</b>	<b>2,844,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,357,840.00	2,196,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	648,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>75,676,597.28</b>	<b>72,939,255.74</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,032,300.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,683,300.00	1,275,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,960,997.28	71,664,255.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,374,562.31</b>	<b>42,167,579.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,014,900.00</b>	<b>12,153,970.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,314,900.00	11,753,970.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>1,389,000.00</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,389,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,359,662.31</b>	<b>28,624,609.92</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,359,662.31	28,624,609.92
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-59,622,145.22</b>	<b>-12,763,566.10</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-59,622,145.22</b>	<b>-12,763,566.10</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>693,669,338.60</b>	<b>700,615,464.99</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>693,669,338.60</b>	<b>700,615,464.99</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>571,353,800.00</b>	<b>559,465,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	571,353,800.00	559,465,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,699,600.00</b>	<b>7,520,100.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,698,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,699,600.00	2,822,100.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>111,615,938.60</b>	<b>133,630,064.99</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	111,615,938.60	133,630,064.99
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>677,830,438.60</b>	<b>695,035,464.99</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>677,830,438.60</b>	<b>695,035,464.99</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>642,668,646.29</b>	<b>652,585,985.07</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>443,793,977.69</b>	<b>433,144,096.88</b>
210101	Үндсэн цалин	289,398,000.00	291,042,877.88
210102	Нэмэгдэл	117,010,177.69	116,945,267.00
210104	Урамшуулал	37,385,800.00	25,155,952.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,152,300.00</b>	<b>56,117,723.20</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,329,400.00	39,263,721.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,455,700.00	4,367,631.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,564,600.00	3,470,585.47
210204	Ажилгүйдлийн даатгал	891,100.00	818,589.05
210205	Эрүүл мэндийн даатгал	8,911,500.00	8,197,195.74
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>111,615,938.60</b>	<b>133,184,464.99</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,851,728.60	8,073,043.23
210302	Түлш, халаалт	101,829,000.00	123,829,701.76
210303	Цэвэр, бохир ус	1,935,210.00	1,281,720.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,482,900.00</b>	<b>6,489,100.00</b>
210401	Бичиг хэрэг	189,900.00	352,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,140,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	178,200.00	1,551,200.00
210404	Ном, хэвлэл	471,500.00	1,815,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,093,300.00	342,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,410,000.00	928,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>9,842,390.00</b>	<b>14,831,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	142,500.00
210502	Хоол, хүнс	9,027,390.00	13,717,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	665,000.00	971,800.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>750,000.00</b>	<b>2,756,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	1,620,000.00
210604	Урсгал засвар	650,000.00	1,136,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,000.00</b>	<b>126,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	84,000.00	126,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,493,840.00</b>	<b>4,661,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,917,840.00	4,013,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	648,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,453,300.00</b>	<b>1,275,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,032,300.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,421,000.00	1,275,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,161,792.31</b>	<b>42,449,479.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,802,130.00</b>	<b>12,435,870.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,102,130.00	12,035,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>1,389,000.00</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,389,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,359,662.31</b>	<b>28,624,609.92</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,359,662.31	28,624,609.92
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>15,838,900.00</b>	<b>5,580,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>15,838,900.00</b>	<b>5,580,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,838,900.00</b>	<b>5,580,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,838,900.00</b>	<b>5,580,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,838,900.00	5,580,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-15,838,900.00</b>	<b>-5,580,000.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-592,934,649.55	1,208,171,965.12
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-592,934,649.55	1,208,171,965.12
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-59,622,145.22	-59,622,145.22
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-652,556,794.77	1,148,549,819.90
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-652,556,794.77	1,148,549,819.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-652,556,794.77	1,148,549,819.90
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-12,763,566.10	-12,763,566.10
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-665,320,360.87	1,135,786,253.80

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	700,982,900.00	664,470,755.07	36,512,144.93	94.79
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	700,982,900.00	664,470,755.07	36,512,144.93	94.79
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	684,552,800.00	652,034,885.07	32,517,914.93	95.25
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	442,620,100.00	433,144,096.88	9,476,003.12	97.86
210101	Үндсэн цалин	305,491,600.00	291,042,877.88	14,448,722.12	95.27
210102	Нэмэгдэл	111,961,700.00	116,945,267.00	-4,983,567.00	104.45
210104	Урамшуулал	25,166,800.00	25,155,952.00	10,848.00	99.96
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,222,800.00	56,117,723.20	2,105,076.80	96.38
210201	Тэтгэврийн даатгал	40,518,100.00	39,263,721.54	1,254,378.46	96.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,426,200.00	4,367,631.40	58,568.60	98.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,540,900.00	3,470,585.47	70,314.53	98.01
210204	Ажилгүйдлийн даатгал	885,200.00	818,589.05	66,610.95	92.48
210205	Эрүүл мэндийн даатгал	8,852,400.00	8,197,195.74	655,204.26	92.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	141,072,000.00	133,184,464.99	7,887,535.01	94.41
210301	Гэрэл, цахилгаан	9,583,500.00	8,073,043.23	1,510,456.77	84.24
210302	Түлш, халаалт	129,322,300.00	123,829,701.76	5,492,598.24	95.75
210303	Цэвэр, бохир ус	2,166,200.00	1,281,720.00	884,480.00	59.17
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,662,000.00	4,658,000.00	4,000.00	99.91
210401	Бичиг хэрэг	201,300.00	201,300.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,551,200.00	1,551,200.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	382,300.00	382,300.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	98,900.00	95,200.00	3,700.00	96.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	928,300.00	928,000.00	300.00	99.97
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,290,300.00	14,831,500.00	12,458,800.00	54.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	143,500.00	142,500.00	1,000.00	99.30
210502	Хоол, хүнс	26,175,000.00	13,717,200.00	12,457,800.00	52.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	971,800.00	971,800.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,536,500.00	7,536,500.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,400,000.00	6,400,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,136,500.00	1,136,500.00	0.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	136,000.00	126,000.00	10,000.00	92.65
210702	Дотоод албан томилолт	136,000.00	126,000.00	10,000.00	92.65
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,737,600.00	1,161,600.00	576,000.00	66.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	513,600.00	513,600.00	0.00	100.00

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,224,000.00	648,000.00	576,000.00	52.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,275,500.00	1,275,000.00	500.00	99.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,275,500.00	1,275,000.00	500.00	99.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,430,100.00	12,435,870.00	3,994,230.00	75.69
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,430,100.00	12,435,870.00	3,994,230.00	75.69
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,030,100.00	12,035,870.00	3,994,230.00	75.08
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	700,982,900.00	664,470,755.07	36,512,144.93	94.79
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	559,465,300.00	530,840,690.08	28,624,609.92	94.88
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	559,465,300.00	530,840,690.08	28,624,609.92	94.88
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	141,517,600.00	133,630,064.99	7,887,535.01	94.43
320001	Орон нутгийн төсвөөс	141,517,600.00	133,630,064.99	7,887,535.01	94.43
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	352.00	335.00	17.00	95.17
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	36.00	36.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	0.00	100.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	279.00	262.00	17.00	93.91
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	279.00	262.00	17.00	93.91
630001	Төрийн өмчит ЕБС	279.00	262.00	17.00	93.91
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	36.00	36.00	0.00	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	24.00	24.00	0.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	<b>7,520,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	<b>7,520,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	<b>6,131,100.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	<b>1,831,100.00</b>
210401	Бичиг хэрэг	0.00	151,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	1,433,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	247,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	<b>4,300,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	<b>1,389,000.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	<b>1,389,000.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,389,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	<b>7,520,100.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	<b>7,520,100.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,698,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	2,822,100.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	0.00	<b>0.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн /цаашид Орхонтуул сумын 1 дүгээр сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ны аудитор А.Батболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын 1 дүгээр сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхонтуул сумын 1 дүгээр сургууль нь “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, сурлагын хоцрогдолгүй сургахад, бүх талуудтай хамтран ажиллая” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Орхонтуул сумын 1 дүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

### **3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын 1 дүгээр сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 765,416.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,654.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 5,357.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Орхонтуул сумын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,360.7 мянган төгрөгөөр

буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,581.2	1,816.9	235.7
Бараа материал	23,922.8	43,211.7	19,288.9
Үндсэн хөрөнгө	1,133,718.4	1,090,833.1	(42,885.3)
Нийт хөрөнгө	1,159,222.4	1,135,861.7	(23,360.7)
Өр төлбөр	10,672.6	75.5	(10,597.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,148,549.8	1,135,786.2	(12,763.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,159,222.4	1,135,861.7	(23,360.7)

Тайлант онд хувь хүнээс авах авлагаас 314.5 мянган төгрөгийг барагдуулан, 2018-2021 онуудад ажилчдын цалин хөлснөөс тооцсон, нийгмийн даатгалын тайлан зөрүүтэй тайлагнаснаас үүссэн 550.2 мянган төгрөгийг НДШ-ийн авлагаар тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43,211.7 мянган төгрөг болж 19,288.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 36,063.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-наас 14,556.3 мянган төгрөгөөр нийлүүлэгдсэн 82 нэр төрлийн 216 ширхэг биологи, лабораторийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 164.6 мянган төгрөгийн халуун хэмжигч, Жайка олон улсын байгууллагаас 169.0 мянган төгрөгийн автомакс, БСГ-аас 1,089.6 мянган төгрөгийн сурах бичиг, Синапс ХХК-аас нийлүүлэгдсэн 14,556.3 мянган төгрөгийн зэрэг нийт 15,979.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 32,753.7 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,404,165.6 мянган төгрөг болж өмнөх оноос 28,779.0 мянган төгрөгөөр өссөн нь 5,580.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж төсвийн хөрөнгөөр худалдан авсан, БСГ-аас 1,715.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 12,413.4 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, 1,160.0 мянган төгрөгийн ном, 7,910.0 мянган төгрөгийн үнэ бүхий биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд түлш халаалтын өглөг дансны эхний үлдэгдэл болох 10,672.6 мянган төгрөгийг барагдуулж, ажилчдын сахилгын шийтгэлийн суутгалыг хүү торгуулийн дансанд шилжүүлээгүйгээс бусад өглөг дансны үлдэгдэл 75.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,135,786.2 мянган төгрөг болж 12,763.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 739,794.0 мянган төгрөг болж өмнөх оноос 33,999.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Энэ нь 25,293.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 752,557.5 мянган төгрөг болж өмнөх оноос 12,858.9 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан нь цалингийн зардал 10,120.8 мянга, НДШ-ын зардал 4,189.1 мянган төгрөгөөр тус тус буурснаас голлон шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Орхонтуул сумын 1 дүгээр сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 751,205.2 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 50,222.3 мянган төгрөгөөр бууруулж, **700,982.9** мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 700,982.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 559,465.3 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 141,517.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 559,465.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 133,630.1 мянган төгрөг, нийт 693,095.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **664,470.8** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 28,624.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 664,470.8 мянган төгрөг буюу 94.8 хувьтай тайлагнагдсан нь цалин урамшууллын зардлыг 9,476.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 2,105.1 мянган төгрөгөөр, норматив зардлыг 12,458.8 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 7,887.5 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлыг 3,994.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд тендерийн орлого 151.0 мянган төгрөг, БСГ-аас 4,457.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгалын зардалд 247.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,300.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 151.0 мянган төгрөгийг зарцуулж, түрээсийн номын орлогын 2,822.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

**3.7.1** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”* гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%”* гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

**3.7.2** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “Короновируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Орхонтуул сумын 1 дүгээр сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 700,982.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 664,470.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.2 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Орхонтуул сумын 1 дүгээр сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 4,474.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 3,716.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 83,019.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 54,448.7 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,763.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 26,808.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

- Тайлант онд 70.0 мянган төгрөгийн эмийг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд тухайн оны батлагдсан төлөвлөгөөг 15,381.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүнгийн тайлан 13,218.8 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Авлагын дэлгэрэнгүй тайлангийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн дүнгээс 1,859.8 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн

- Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны зэрэгцүүлсэн тайлангийн дүнг 23,918.4 мянган төгрөгийн тус тус зөрүүтэй илэрхийлсэн алдааг аудитын явцад залрууллаа.

## 4.2 Албан шаардлага

1. Захирал Д.Долгормаад сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/328 дугаар захирамжаар 964.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 4.6. “Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүйгээс ХХОАТ, НДШ-ийн 722.5 мянган төгрөгийн авлага, цалингийн 75.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх

## 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

### 1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 26,808.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар

төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

### 1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1. Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансанд мэдээлбэл зохих 12 мэдээллийг хугацаа хоцроон, 3 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	8	83,019.9	5	54,448.7			2	1,763.0	1	26,808.2